**ДУНДГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН**
**2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

**2022.06.15**

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** *⁄ Барилгын тухай хууль, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам/* | | | | | | | |
| 1.1 | **ЗОРИЛТ 1: УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАХ** | | | | | | |
| 1.1.1 | Салбарын эрх зүйн орчны хүрээнд хууль, дүрэм, журамд санал өгөх, хууль, тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах, нийтийн аж ахуйн байгууллагуудын үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах | - | 1.Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 166 дугаар тушаалаар батлагдсан “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний байгууллагуудын гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах нийтлэг журам” 2. “Ус” үндэсний хөтөлбөр /УИХ- | 4 тайлан | Холбогдох тайлан мэдээг хугацаандаа Барилгын хөгжлийн төвд ирүүлсэн байна | Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 166 дугаар тушаалаар батлагдсан “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний байгууллагуудын гамшгаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-тай хамтран боловсруулан, батлуулахаар ажиллаж байна. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ын 2010 оны 24 дүгээр тогтоол/-ын үе шатны зорилт 3.Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх. | | | | |
| 1.1.2 | БМ 33 Маягтын дагуу Нийтийн аж ахуйн нэгж байгууллагын үйлчилгээний үнийн тайлан, мэдээг нэгтгэн Барилгын хөгжлийн төвд хүргүүлэх | - | Мэдээлэл үнэн зөв байх | 1 тайлан | Холбогдох тайлан мэдээг хугацаандаа Барилгын хөгжлийн төвд илгээсэн байна | Нийтийн аж ахуйн нэгж байгууллагын үйлчилгээний үнийн мэдээг БМ-33 маягтийн дагуу гаргаж тус байгууллагын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 3/100 тоот албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. | 100 |
| 1.1.3 | Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах | - | Мэдээлэл үнэн зөв байх | 1 төлөвлөгөө | Төлөвлөгөө боловсруулсан байна | Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг “Дундговь-Ус” ОНӨААТҮГ-тай хамтран боловсруулж байна. | ХБ |
| **БАРИЛГЫН САЛБАРЫН НОРМ, НОРМАТИВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД**<br>*/ Барилгын тухай хууль, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам/* | | | | | | | |
| 2.1 | **ЗОРИЛТ 2: ХҮЧИН ТӨГӨЛДӨР МӨРДӨГДӨЖ БАЙГАА БАРИЛГЫН САЛБАРЫН НОРМ НОРМАТИВЫН БАРИМТ БИЧГИЙГ СУРТАЛЧЛАХ, МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ** | | | | | | |
| 2.1.1 | Шинээр батлагдсан барилгын норм, дүрмийг сурталчлах, сургалт зохион байгуулах | - | Холбогдох стандарт норм, дүрэмд нийцсэн байх | 4 удаагийн сургалт | Сургалт зохион байгуулагдсан байх | Салбарын хэмжээнд шинээр батлагдсан тогтоол, шийдвэр болон барилгын норм ба дүрмийг тухай бүрт сурталчлан ажиллаж байна. | 100 |
| **ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД**<br>*/ Барилгын тухай хууль, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам/* | | | | | | | |
| 3.1 | **ЗОРИЛТ 3: ХҮН АМЫН НУТАГШИЛТ СУУРЬШЛЫН ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ АЖИЛЛАХ** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1 | Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлж шаардлагатай мэдээ материалаар хангаж, хамтарч хурал, хэлэлцүүлэг зохион байгуулах | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | Тухай бүр | Хурал хэлэлцүүлэгт оролцсон байна. | Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулахад шаардлагатай мэдээ материалаар тухай бүрт ханган ажиллаж байна. 2022 оны хагас жилийн байдлаар хэлэлцүүлэг зохион байгуулагдаагүй байна. | 30 |
| 3.1.2 | Хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төслийг боловсруулах төслийн багийг орон нутагт судалгаагаар ажиллахад дэмжлэг үзүүлэх | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | Тухай бүр | Төслийн багтай хамтран ажилласан байна. | Төслийн баг 2022 оны хагас жилийн байдлаар орон нутагт ажиллаагүй байна. | ҮБ |
| 3.1.3 | Хүн амын нягтаршил болон сургууль, цэцэрлэгийн эрэлт хэрэгцээний судалгааг маягтын дагуу гаргаж Барилгын хөгжлийн төвд хүргүүлэх | | Бодитой, үнэн зөв байх | 1 багц судалгаа | Судалгаа хийгдсэн байх | Тус аймгийн хэмжээнд нийт 21 сургууль, 20 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд сургууль, цэцэрлэгийн эрэлт хэрэгцээний судалгааг нэгтгэж Барилгын хөгжлийн төвд цахимаар хүргүүлсэн. | 100 |

## ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААР ЯВУУЛАХ ТӨРИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** */ Барилгын тухай хууль, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам/* | | | | | | | |
| 2.1 | **ЗОРИЛТ 1: БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛТАН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭГДСЭН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ШИНЭЧЛЭХ, МЭДЭЭЛЛИЙГ МЭДЭЭЛЛИЙН САНД БАЙРШУУЛАХ, МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ** | | | | | | |
| 2.1. | Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудыг | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | Тухай бүр | Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн | Тус аймгийн харьяалалтай барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 12 аж ахуйн нэгж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлагдсан маягтын дагуу үйл ажиллагааны тайлан мэдээг ирүүлэх ажлыг зохион байгуулах | | | | нэгжүүд тайлангаа цахимаар өгсөн байна. | байгууллагыг цахимаар тайлангаа хүргүүлэх талаар тус байгууллагын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 3/03 тоот албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн. | |
| 2.2 | **ЗОРИЛТ 2: БАРИЛГЫН АЖЛЫН ЧАНАР, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ХЯНАЛТ ТАВИХ** | | | | | | |
| 2.2.1 | Монгол орны нутаг дэвсгэрт учирч болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх чиглэлээр гарсан зөвлөмж, тэмдэглэлүүд, тогтоол, шийдвэрүүдийн биелэлтийг хамтран хэрэгжүүлэх, нэгдсэн тайлан мэдээг гаргах, хүргүүлэх | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | 1 багц тайлан | Төрийн бодлого, чиглэл, эрх зүйн акт, хууль тогтоомж, дүрэм журмуудын уялдаа холбоог сайжруулсан байна. | “Газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тайланг 4 дүгээр улиралд хүргүүлнэ. | ҮБ |
| 2.2.2 | Барилгын ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл, ашиглалтад оруулах асуудлаар хамтран ажиллах, нэгдсэн мэдээ, мэдээллийг тогтсон хугацаанд Барилгын хөгжлийн төвд хүргүүлэх | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | 1 багц тайлан | Улсын хэмжээнд шинээр эхэлсэн болон ашиглалтад орсон барилга байгууламжийн нэгдсэн мэдээ тайлан гарсан байна. | 2022 оны хагас жилийн байдлаар 7 барилга байгууламж, 4 засварын ажлыг ашиглалтад оруулж, 11 барилга байгууламж, засварын ажилд шинээр барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон.<br>Ашиглалтад орсон болон зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээллийг Барилга, хот байгуулалтын сайдын 55 дугаар тушаалаар батлагдсан маягтын дагуу улирал бүр гаргаж 1 дүгээр улирлын тайланг тус байгууллагын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 1/94 тоот албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. | 100 |
| 2.2.3 | Орон нутаг дахь барилга байгууламжийн газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлж, | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | 1 багц тайлан | Улсын хэмжээнд паспортжуулсан барилга | Монгол улсын Шадар сайдын 2017 оны 78 дугаар тушаалаар батлагдсан “Барилга, байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | паспортжуулах үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх нэгдсэн мэдээ, тайланг Барилгын хөгжлийн төвд хүргүүлэх ажлыг зохион байгуулах | | | | байгууламжийн нэгдсэн мэдээ тайлан гарсан байна. | паспортжуулах журам"-ын 2.5.2-т заасны дагуу 2022 онд 5 барилга, байгууламжид ашиглалтын гэрчилгээ олгосон.<br>Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 дахь заалтуудын дагуу ашиглалтын явцад гарсан зөрчлийг тухай бүрт арилгуулан "Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм"-ийн заалтуудыг аймгийн хэмжээнд хангуулан ажиллаж байна. | |
| 2.2.4 | "Газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлсэн талаарх тайланг хүлээн авч, нэгдсэн тайланг Барилгын хөгжлийн төвд хүргүүлэх | - | Холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байх | 1 багц тайлан | Аймаг сумын барилга байгууламжийн газар хөдлөлтийн талаар судалгаа хийж хүргүүлсэн байх. | "Газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Тайланг хагас жилийн байдлаар хүргүүлэхээр ажиллаж байна. | 70 |
| 2.3 | **ЗОРИЛТ 3: БАРИЛГА, НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫН ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГУУЛАХ** | | | | | | |
| 2.3.1 | "Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн" нэг сарын аяныг зохион байгуулахад оролцох. | - | Холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байх | 1 аян | Сарын аян зохион байгуулахад оролцсон байна. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг аймагт 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 28-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулж барилга угсралтын ажил нь эхлэж байгаа улс, орон нутаг, хувийн хөрөнгөөр баригдах барилга байгууламжид бэлтгэл ажил болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаар хангуулах зорилгоор хамгаалалтын хашаа, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, талбайн зохион байгуулалтын зураг, төслийн танилцуулах самбар зэргийг стандартын дагуу байрлуулж аюулгүй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орчин бүрдүүлж ажиллах талаар үүрэг өгч, хяналт тавьж ажиллаа. | |
| **ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙН САЛБАРЫН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД**<br>*/ Барилгын тухай хууль, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам/* | | | | | | | |
| **2.4** | **ЗОРИЛТ 4: УС СУВГИЙН ТУРШИЛТ ТОХИРУУЛГА, ТЕХНИК АШИГЛАЛТ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААГ ХАНГАХ** | | | | | | |
| 2.4.1 | Улсын хэмжээний орон сууц хувьчлалын мэдээллийн сангийн бүрдэлтийг хангах нэмэлт баяжилт хийх, орон сууц хувьчлалын асуудлаар мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх. | - | Мэдээлэл үнэн зөв байх | Тухай бүр | Мэдээллийн санд баяжилт хийгдсэн байна. | Орон сууцны нэгдсэн мэдээллийн санд аймгийн хэмжээнд ашиглагдаж байгаа 78 нийтийн зориулалттай орон сууцны барилгын мэдээллийг оруулсан. 2022 онд ашиглалтад орсон 3 орон сууцны барилгын мэдээллийг мэдээллийн санд оруулж баяжилт хийсэн. | 100 |
| 2.4.2 | Сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран үзлэг шалгалт хийж, ажлын тайланг Барилгын хөгжлийн төвд ирүүлэх | - | Чанартай, үр дүнтэй байх | 1 багц тайлан | Үзлэг, шалгалт зохион байгуулсан байна. | Тус аймгийн хэмжээнд 1 СӨХ үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус СӨХ-ны үйл ажиллагаанд аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран үзлэг, шалгалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | ҮБ |
| 2.4.3 | Нүхэн жорлон, угаадасны нүх техникийн шаардлага MNS 5924:2015 стандартыг хэрэгжүүлэх | - | Хөрсийг эрүүлжүүлэх | 1 багц арга хэмжээ | Стандартыг хэрэгжүүлсэн байх | 2020 онд аймгийн төв болон 14 сумын хөрс бохирдуулагч нүхэн жорлон, угаадасны нүхний тооллого явуулж, судалгааг гаргасан. Тус судалгааг үндэслэн “Хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе шаттайгаар бууруулах” төлөвлөгөө боловсруулан, аймгийн Засаг даргын тамгын газраар батлуулан, төлөвлөгөөний дагуу аймгийн ОНХС-ийн хөрөнгөд 85,0 сая төгрөг батлуулан эхний ээлжинд улсын чанартай авто замын дагуу болон цэцэрлэгт хүрээлэн, наамдын талбай гэх мэт олон нийтийн газрууд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 36 ширхэг сайжруулсан ариун цэврийн байгууламж байрлуулсан. | |
| **САЛБАРЫН УДИРДАХ БОЛОН ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНЫГ МЭРГЭШҮҮЛЭХ, ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ" ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД** *| Барилгын тухай хууль, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам/* | | | | | | | |
| 2.5 | **ЗОРИЛТ 5: САЛБАРЫН МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ СУНГАХ, АХИУЛАХ МЭРГЭЖИЛТЭНД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫГ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАХ** | | | | | | |
| 2.5.1 | Мэргэшлийн зэрэг горилох, сунгах, ахиулах багц цаг тооцох мэргэшүүлэх сургалтад аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтнүүд болон орон нутгийн инженер, техникийн ажилтнуудыг хамруулах, хамтран ажиллах | - | БХБСайдын 2017 оны 200 дугаар тушаалд нийцсэн байх, салбарын холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн байх | 1 сургалт | Сургалт амжилттай зохион байгуулагдаж инженер техникийн ажилтнууд хамрагдсан байх | Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний зохицуулах зөвлөл, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс хамтран 2022 он 05 дугаар сарын 12-13-ны өдөр Төв аймгийн Зуунмод хотод зохион байгуулагдсан "Орон нутагт эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах" сэдэвт мэргэжил дээшлүүлэх 1,5 багц цаг тооцох бүсийн сургалтад тус байгууллагын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, мэргэжилтэнүүд болон тус аймагт эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн удирдлагууд, инженерүүд, зэрэг 24 хүн хамрагдаж гэрчилгээ гардан авсан. | 100 |
| 2.6 | **ЗОРИЛТ 6: САЛБАРЫН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫГ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАХ** | | | | | | |
| 2.6.1 | Орон нутгийн инженер техникийн ажилтанд зориулсан багц цаг тооцох чадавхжуулах сургалтыг аймаг, бүсийн хэмжээнд зохион байгуулж, ИТА-г идэвхтэй хамруулах. | - | Салбарын холбогдох бусад хууль, тогтоомж, БНбД, стандарт, журам, аргачлал болон тавигдсан шаардлагад нийцсэн байх. | 1 багц сургалт | Сургалт амжилттай зохион байгуулагдаж инженер техникийн ажилтнууд | Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний зохицуулах зөвлөл, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс хамтран 2022 он 05 дугаар сарын 12-13-ны өдөр Төв аймгийн Зуунмод хотод зохион байгуулагдсан "Орон нутагт эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх үйл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сургалтад хамрагдагсдын сэтгэл ханамж 80%-иас доошгүй байх | | хамрагдсан байх | ажиллагааны төлөвлөгөө боловсруулах" сэдэвт мэргэжил дээшлүүлэх 1,5 багц цаг тооцох бүсийн сургалтад тус байгууллагын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, мэргэжилтэнүүд болон тус аймагт эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн удирдлагууд, инженерүүд, зэрэг 24 хүн хамрагдаж гэрчилгээ гардан авсан. Мөн орон нутгийн инженер техникийн ажилтанд зориулсан чадавхжуулах сургалтыг 2022 оны 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. | |
| **БАРИЛГЫН САЛБАРЫН СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АЖЛЫН ХҮРЭЭНД**<br>*/ Барилгын тухай хууль, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам/* | | | | | | | |
| 2.7 | **ЗОРИЛТ 7: САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ШААРДЛАГАТАЙ БАЙГАА СУДАЛГАА ХИЙХ, СУДАЛГААНЫ ҮР ДҮНД МОНИТОРИНГ ХИЙХ, ТАЙЛАНГ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ** | | | | | | |
| 2.7.1 | Улсын хэмжээнд ашиглалтад орсон орон сууцны судалгааг маягтын дагуу гаргаж Барилгын хөгжлийн төвд хүргүүлэх | - | Бодитой, үнэн зөв байх | 1 судалгаа | Судалгааг маягтын дагуу ирүүлсэн байх | Аймгийн хэмжээнд ашиглалтад орсон орон сууцны судалгааг 3 дугаар улиралд хүргүүлнэ. | ҮБ |
| 2.7.2 | Орон нутагт шаардлагатай байгаа инженер, техникийн ажилтан болон мэргэжилтэй ажилчдын судалгааг гаргаж Барилгын хөгжлийн төвд хүргүүлэх | - | Бодитой, үнэн зөв байх | 1 судалгаа | Судалгаа хийж, дүнг ирүүлсэн байх | Аймгийн хэмжээнд барилгын салбарт ажиллаж байгаа 58 инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдын судалгааг гаргаж тус байгууллагын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 1/185 тоот албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. | 100 |
| 2.8 | **ЗОРИЛТ 8: САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАХ** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.8.1 | Орон нутагт салбарын хэмжээнд зохион байгуулагдаж буй үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх, сурталчлах | - | Бодитой, үнэн зөв байх | 1 багц сурталчлах ажил | Зохион байгуулсан арга хэмжээ бүр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүрсэн байх | Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, БНбД-ийг байгууллагын цахим хуудас, фэйсбүүк хуудас болон мэдээллийн самбарт байршуулан иргэдэд ил тод нээлттэйгээр сурталчилж байна. Мөн аймгийн хэмжээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, барилга байгууламжийн угсралтын ажлын явцын мэдээллийг тухай бүрт байгууллагын цахим сайтуудад байршуулан мэдээллийг тухай бүр шинэчлэн олон нийтэд сурталчилж байна. | 100 |
| 2.9 | **ЗОРИЛТ 9: "БАРИЛГЫН МЭДЭЭЛЭЛ" ЭМХЭТГЭЛД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ, НИЙТЛҮҮЛЭХ, ЭМХЭТГЭЛИЙГ ОРОН НУТАГТ СУРТАЛЧЛАХ** | | | | | | |
| 2.9.1 | "Барилгын мэдээлэл" эмхэтгэлд орон нутагт хийгдсэн бүтээн байгуулалт болон салбарын техник технологийн талаар мэдээлэл бэлтгэж өгөх | - | Шаардлагатай мэдээллүүдийг багтаасан байх | Тухай бүр | "Барилгын мэдээлэл" эмхэтгэлд мэдээлэл нийтлүүлсэн байх | "Барилгын мэдээлэл" эмхэтгэлийн 2022 оны тусгай дугаарт байгууллагын товч танилцуулга болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус аймагт хэрэгжиж буй 13 барилга байгууламжийн явцын мэдээлэл, танилцуулгыг бэлтгэн хэвлүүлсэн. | 100 |

## ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД** *Барилгын тухай хууль, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам/* | | | | | | | |
| 3.1 | **ЗОРИЛТ 1: БАРИЛГА, БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1 | Аймгийн нутаг дэвсгэрт батлагдаагүй барилга байгууламжийн зураг төслөөр барилга байгууламж бариулахгүй байх арга хэмжээг авч ажиллах | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | Тухай бүр | Батлагдаагүй барилга байгууламжийн зураг төслөөр барилга баригдахгүй байх | Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, бэлтгэл ажлыг хангуулах, үе шатны дагуу зураг төслийг боловсруулах, магадлал хийх ажлыг зохион байгуулахад Засгийн газрын 2018 оны 97 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж байна. 2022 онд 14 архитектур төлөвлөлтийн даалгаврыг дүрмийн дагуу боловсруулан баталж, хөрөнгө оруулагч, захиалагч нарт хүргүүлсэн. Мөн 11 ажлын зураг төслийг магадлалаар баталгаажуулсны дараа барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон. Батлагдаагүй барилга байгууламжийн зураг төслөөр баригдаж буй барилга байхгүй болно. | 100 |
| 3.1.2 | Аймгийн нутаг дэвсгэрт баригдах барилга байгууламжийг батлагдсан зургийн дагуу, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм нормативыг мөрдүүлж ажиллах | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | Тухай бүр | Барилга байгууламжийг норм, нормативын дагуу баригдсан байна. | Аймгийн хэмжээнд улс, орон нутаг, хувийн хөрөнгөөр хэрэгжих барилга байгууламжийн угсралтын ажлыг ажлын зураг төслийг магадлалаар баталгаажсны дараа эхлүүлэн, зураг төслийн дагуу гүйцэтгэж буй эсэхэд үе шатны ажил бүрт захиалагчийн хяналт гүйцэтгэн ажиллаж байна. | 100 |
| **БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЛААР ЯВУУЛАХ ТӨРИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД** */ Барилгын тухай хууль, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам/* | | | | | | | |
| 3.2 | **ЗОРИЛТ 2: ДОТООДЫН БОЛОН ИМПОРТЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНД ХАМРУУЛАХ АЖЛЫГ ЗОХИХ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛАХ** | | | | | | |
| 3.2.1 | Орон нутгийн барилгын материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүнийг тохирлын баталгаажуулалтад | - | Холбогдох хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцсэн байх | Тухай бүр | Орон нутагт Тохирлын гэрчилгээ эзэмшигчдийн | Аймгийн хэмжээнд барилгын материал үйлдвэрлэж буй аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүст үйлдэрлэж буй бүтээгдэхүүнээ тохирлын гэрчилгээтэй болгож, | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | | | | тоо нэмэгдсэн байна | барилгын үйлдвэрлэлд нийлүүлэх мөн тус байгууллагатай хамтран ажиллах талаар чиглэл хүргүүлсэн. | |
| 3.2.2 | Орон нутагт баригдаж буй барилга байгууламжуудад тохирлын гэрчилгээтэй барилгын материал, бүтээгдэхүүн хэрэглүүлэх ажлыг зохион байгуулах | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | Тухай бүр | Зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна | Улс, орон нутгийн төсөв, хувийн хөрөнгөөр баригдаж буй барилга байгууламжид захиалагчийн хяналт гүйцэтгэж, тохирлын гэрчилгээтэй бараа материал, бүтээгдэхүүн хэрэглэх талаар чиглэл өгч, хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 3.3 | **ЗОРИЛТ 3: БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭР ШИНЭЭР БАЙГУУЛАХ, ӨРГӨТГӨХ, ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛТ ХИЙХ АЖЛЫН УРЬДЧИЛСАН СУДАЛГААГ ХИЙХ, САНАЛ БОЛОВСРУУЛАХ, ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГАД ТАВЬЖ ШИЙДВЭРЛҮҮЛЭХ** | | | | | | |
| 3.3.1 | Барилгад хэрэглэх гол нэрийн барилгын материалын үнийн төрөлжсөн судалгааг орон нутгийн хэмжээнд хийх, хүргүүлэх, мэдээллээр хангах | | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | Тухай бүр | Судалгааг үндэслэн мэдээллийн санд баяжилт хийгдсэн байна | Барилгад хэрэглэж буй гол нэрийн барилгын материалын үнийн судалгаа тухай бүрт гаргаж мэдээлийн санг баяжуулсан. Тус мэдээллийг байгууллагын цахим сайт, мэдээллийн самбарт байршуулан орон нутгийн ААНБ-ууд болон иргэдийг мэдээллээр хангаж ажиллаж байна. | 100 |
| 3.3.2 | Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөр хамгаалал, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, холбогдох Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | Тухай бүр | Хамтран ажилласан байна | 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдөр аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран "Барилгын үйлдвэрлэлийн талбай ба өргөх байгууламжийн аюулгүй ажиллагаа" сэдэвт сургалтыг зохион байгуулж тус аймагт үйл ажиллагаа явуулж буй өргөх байгууламж, машин механизмтай хувь хүн болон барилга угсралтын компаниудын захирал, инженер, талбайн даамал, хөдөлмөр хамгааллын инженерүүдийг тус сургалтад хамруулж холбогдох сэдвүүдээр мэдээлэл өгсөн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.4 | **ЗОРИЛТ 5: УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БАРИГДАХ БАРИЛГЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГААНД БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛӨН ОРОЛЦОХ** | | | | | | |
| 3.4.1 | Барилга байгууламжийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах орон нутгийн үйл ажиллагаанд оролцох, холбогдох мэдээ мэдээллээр хангаж, нэгдсэн тайлан мэдээг гаргаж хүргүүлэх | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | Тухай бүр | Мэдээллийг холбогдох байгууллагад тухай бүр өгч, тайлан мэдээг гаргасан байна. | 20212 онд улсын төсвийн, орон нутгийн хөгжлийн сан болон бусад төсөл хөтөлбөрийн нийт 21 барилга байгууламж, засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зохион байгуулагдсан. Үүнээс тус байгууллагын 3 албан хаагч 9 үнэлгээний хороонд оролцон холбогдох мэдээ, мэдээллээр тухай бүрт хангаж ажилласан. | 100 |
| 3.5 | **ЗОРИЛТ 5: БАРИЛГЫН МАТЕРИАЛД СОРИЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ** | | | | | | |
| 3.5.1 | Барилгын материал, хийц бүтээцийн дээжийг хүлээн авч сорилт шинжилгээ хийж дүгнэлт гаргах, архивлан хадгалах | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | 50 | Лабораторид ирсэн дээжид шинжилгээ хийж дүгнэлт гарч баталгаажуулагдсан байна. | Тус лаборатори нь 47 төрлийн тоног төхөөрөмжтэй бөгөөд 30 гаруй төрлийн шинжилгээг хийх боломжтой болсон. 2022 оны хагас жилийн байдлаар шинжилгээ хийж дүгнэлт гаргаагүй. Орон нутагт хэрэгжиж буй барилга байгууламжийн угсралтын ажилд хэрэглэж буй бүх төрлийн хийцэд Барилгын хөгжлийн төвийн итгэмжлэгдсэн лаборатори болон бусад итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлт гаргуулан шинжилгээний дүгнэлтийг архивлан хадгалж байна. | 70 |
| 3.5.2 | Барилгын материалын лабораторид ирсэн дээжээс Барилгын хөгжлийн төвийн Барилгын материал сорилт шинжилгээний лабораторид ирүүлж, шинжилгээний хариунд гадаад хяналт хийлгэх | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | 2-3 удаагийн хяналт | Гадаад хяналт хийгдсэн байна. | Тус байгууллагын барилгын материалын лабораторийн зориулалтын байргүйн улмаас үйл ажиллагаа нь жигдрээгүй байна. Барилгын материалын лабораторийн шинжилгээг Барилгын хөгжлийн төвийн итгэмжлэгдсэн лабораториор хийлгэн дүгнэлт гаргуулж байна. | ХБ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5.3 | Төвийн Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид лабораторийн лаборантуудыг чадавхжуулах, дадлагажуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол авах | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | 1 багц арга хэмжээ | Мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг авсан байх | Тус байгууллагын Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори нь 25 нэр төрлийн тоног төхөөрөмжтэй бөгөөд Барилгын хөгжлийн төвийн Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторид лаборантуудыг чадавхжуулах, дадлагажуулах талаар хамтран ажиллахаар төлөвлөж байна. | ХБ |
| 3.5.4 | Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн үйл ажиллагааны тайланг гаргаж ирүүлэх | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | 2 удаа тайлан гаргах | Барилгын материалын сорилт шинжилгээний үйл ажиллагааны тайлан гарсан байна. | Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн үйл ажиллагааны хагас жилийн тайланг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлэхээр ажиллаж байна. | 70 |
| **БАРИЛГЫН САЛБАРЫН НОРМ, НОРМАТИВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД**<br>*/ Барилгын тухай хууль, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, норм, стандарт/* | | | | | | | |
| 3.6 | **ЗОРИЛТ 6: БАРИЛГЫН НОРМ НОРМАТИВЫН САНД ХӨРӨНГӨ ТӨВЛӨРҮҮЛЭХ** | | | | | | |
| 3.6.1 | Барилгын норм норматив боловсруулах санд улс, орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлаас барилгын норм нормативын санд хөрөнгө төвлөрүүлэх, хамгийн их хөрөнгө төвлөрүүлсэн аж ахуйн нэгжийг шалгаруулж, арга хэмжээнд орон нутгийн аж ахуйн нэгж байгууллагыг идэвхтэй хамруулах зохион байгуулах | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | 1 удаагийн шалгаруулалт | 10 аж ахуйн нэгж шалгарсан байна. | Аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга, байгууламжийн төсөвт өртгөөс “Барилгын тухай хууль”-д заасны дагуу норм, нормативын санд шимтгэлийг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан 2022 оны хагас жилийн байдлаар Барилгын хөгжлийн төвийн Худалдаа хөгжлийн банкны 2600078533 тоот дансанд 3 аж ахуйн нэгж байгууллага 1,150,000 төгрөг төвлөрүүлсэн бөгөөд тайланг 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1/184 тоот албан бичгээр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. | |
| **БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД**<br>*/ Барилгын тухай хууль, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам/* | | | | | | | |
| 3.7 | **ЗОРИЛТ 7: УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН АЖЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХЯНАЛТ ХИЙХ** | | | | | | |
| 3.7.1 | Барилга, хот байгуулалтын сайдын багцад батлагдсан улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих барилга байгууламжийн захиалагчийн хяналт гүйцэтгэх, ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах | - | Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, БНбД-ийн хүрээнд батлагдсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгүүлэх | Тухай бүр | Барилгын ажлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, БНбД-ийн хүрээнд батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгүүлэх | Азийн Хөгжлийн Банкны зээлийн санхүүжилттэй Эрдэнэдалай сумын төвийн 50м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын шугам, цэвэр усны шугамын барилга угсралтын ажлыг “Сайн констракшн” гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын явц 90 хувьтай байна. Тус барилга угсралтын ажилд 1 удаа захиалагчийн хяналт гүйцэтгэсэн.<br>Сайхан-Овоо сумын төвийн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажлыг “Эхлэл шинэчлэл прожект” ХХК 1,814 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байгаа бөгөөд явц 53 хувьтай. 2022 оны 06 сарын байдлаар барилгын ажил эхлээгүй байна. | 100 |
| 3.7.2 | Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад батлагдсан Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих барилга байгууламжийн захиалагчийн хяналт гүйцэтгэх, ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах | - | Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, БНбД-ийн хүрээнд батлагдсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгүүлэх | Тухай бүр | Барилгын ажлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, БНбД-ийн хүрээнд батлагдсан зураг төслийн | Гурвансайхан сумын 100 ортой сургуулийн дотуур байрны барилга угсралтын ажил мөн<br>Сайнцагаан сумын 960 суудалтай Говийн ирээдүй цогцолбор сургуулийн барилгын ажил 2022 оны 06 сарын байдлаар эхлээгүй байна. Сайхан-Овоо сумын 320 суудалтай сургууль, спорт заалны барилгын ажлын явц 50 хувьтай. Тус барилгад 2 удаа захиалагчийн хяналт гүйцэтгэсэн. 2022 оны улсын төсөвт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дагуу гүйцэтгүүлэх | батлагдсан шинээр хэрэгжих 5 барилгын ажил эхлээгүй байна. | |
| 3.7.3 | Эрүүл мэндийн сайдын багцад батлагдсан Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих барилга байгууламжийн захиалагчийн хяналт гүйцэтгэх, ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах | - | Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, БНбД-ийн хүрээнд батлагдсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгүүлэх | Тухай бүр | Барилгын ажлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, БНбД-ийн хүрээнд батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгүүлэх | Сайнцагаан сумын 100 ортой нэгдсэн эмнэлгийн барилгын угсралтын ажилд 3 удаа захиалагчийн хяналт гүйцэтгэсэн. БНХАУ-ын хил гааль хаагдаж, барилгын материалын тээвэрлэлт, нийлүүлэлтээс шалтгаалан барилга угсралтын ажил удааширч гэрээт хугацаандаа ашиглалтад оруулах боломжгүй болох магадлалтай байна. Мөн Эрдэнэдалай сумын 22 ортой сум дундын эмнэлгийн гадна тохижилтын ажлын зөвшөөрөл олгосон. Бэлтгэл ажлаа хангаж байна. | 100 |
| 3.7.4 | Соёлын сайдын багцад батлагдсан Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих барилга байгууламжийн захиалагчийн хяналт гүйцэтгэх, ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах | - | Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, БНбД-ийн хүрээнд батлагдсан зураг төслийн дагуу хийж гүйцэтгүүлэх | Тухай бүр | Барилгын ажлыг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт, БНбД-ийн хүрээнд батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгүүлэх | Дэлгэрцогт сумын 240 суудалтай соёлын төвийн барилга угсралтын ажилд 1 удаа захиалагчийн хяналт гүйцэтгэсэн.<br>Дээрх ажлуудад захиалагчийн хяналт гүйцэтгэсэн тайланг хагас жилийн байдлаар Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. | 100 |
| **ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АЖЛЫН ХҮРЭЭНД**<br>*/ Барилгын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам/* | | | | | | | |
| 3.8 | **ЗОРИЛТ 8: ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХАМТРАН АЖИЛЛАХ** | | | | | | |
| 3.8.1 | Салбарын хүний нөөцийн болон чадавхыг дээшлүүлэх, туршлага | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | 1-2 удаагийн | Уулзалт, семинарт оролцсон байх | 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр ГЗБГЗЗГ-аас зохион байгуулсан аймгуудын ГХБХБГ-ын удирдах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | солилцох уулзалт, семинарт оролцох | | | уулзалт, семинар | | ажилтны зөвлөгөөнд тус байгууллагын дарга хамрагдсан. 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдөр БХТөвөөс зохион байгуулсан аймгуудын ГХБХБГ-ын дарга нартай хийх зөвлөлдөх уулзалтад тус байгууллагын дарга болон Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга нар хамрагдсан. 2022 оны 02 дугаар 24-25-ны өдрүүдэд Сангийн яамнаас зохион байгуулсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалт, үр ашиг” сэдэвт сургалтад аймгийн ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэнгүүд болон тус байгууллагын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга хамрагдсан. Мөн 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдөр БХБЯ-аас зохион байгуулсан “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хэлэлцүүлэгт аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга, холбогдох мэргэжилтэн болон эхний ээлжинд хамрагдах боломжтой сумдын ЗД нарын хамт цахимаар оролцсон. | |
| 3.8.2 | Салбарын хэмжээнд жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, бүтээгдэхүүн үйлчилгээ, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хагас, бүтэн жилээр | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | 2 удаагийн холбогдох тайлан | Хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулж, хэрэгжүүлсэн байх, шаардлагатай судалгаа, | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбарын төлөвлөгөөний тус байгууллагад холбогдолтой заалтуудын хэрэгжилтийг гаргаж 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр ГЗБГЗЗГ-ын Ахлах мэргэжилтэн С.Ганцэцэгт файлаар хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь. Хүний эрхийн үндэсний комиссоос НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайланд тусгах, шаардлагатай судалгаа, мэдээллийг ирүүлэх | | | | мэдээллийг ирүүлсэн байх | “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төсөл, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (Койка)-тай хамтран жендэрийн мэдрэмжтэй эрэгтэй удирдагчдыг орон нутгийн түвшинд шалгаруулсан. Дээрх сонгон шалгаруулалтад 19 аймгийн 170 гаруй байгууллагын 1800 гаруй албан хаагч хамрагдаж аймаг бүрт гурван салбараар жендэрийн мэдрэмжтэй 29 удирдагчийг шалгаруулсан ба тус байгууллагын дарга Э.Чагнаадорж шалгарсан.<br>Мөн Хүний эрхийн үндэсний комиссын Дундговь аймаг дахь референт Т.Баярцэцэг “Жендерийн эрх тэгш байдал” сэдэвт сургалтыг тус байгууллагын нийт албан хаагчдад зохион байгуулсан. | |
| 3.9 | **ЗОРИЛТ 9: ДОТООД ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ТАЙЛАН МЭДЭЭГ ХҮРГҮҮЛЭХ** | | | | | | |
| 3.9.1 | Гүйцэтгэлийн тайлан, мэдээг хагас бүтэн жилээр гаргаж, тогтсон хугацаандаа багтааж Барилгын хөгжлийн төвд хүргүүлэх | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | 2 удаагийн багц тайлан | Тайлан хугацаандаа гарсан байх | Гүйцэтгэлийн тайлан, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй барилга байгууламжийн захилагчийн хяналт гүйцэтгэсэн хагас жилийн тайланг Барилгын хөгжлийн төвд тус тус хүргүүлсэн. | 100 |
| 3.9.2 | Барилгын хөгжлийн төвтэй холбоотой санхүүгийн бүртгэл, өглөг авлагын тооцоо нийлж, тайлан мэдээг тухай бүр гарган ирүүлж, хамтран ажиллах | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | 2 удаагийн багц тайлан | Тайлан хугацаандаа гарсан байх | Барилгын хөгжлийн төвтэй холбоотой санхүүгийн бүртгэл, өглөг авлагын тооцоог тухай бүр гаргаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.9.3 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа орон нутагт эрх шилжсэн төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтын зардлыг тухай бүр тооцоо нийлэн шилжүүлэх | - | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх | Тухай бүр | Тайлан хугацаандаа гарсан байх | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орон нутагт эрх нь шилжсэн төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг аймгийн ЗДТГ-тай гэрээ байгуулан гүйцэтгэж, зардлыг тухай бүрт өөрийн орлогын дансанд шилжүүлж авч байна. | 100 |
| **Дундаж хувь**<br>100 хувь-31, 70 хувь 4, 30 хувь-1, ҮБ-5 | | | | | | | **94,7** |

**ҮНЭЛГЭЭ ӨГСӨН:** **ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ:**

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ ........................................................... /Ц.АМАРСАНАА/

*(албан тушаал)* *(гарын үсэг ) (тэмдэг)*

.....................

**ТАЙЛАН БИЧСЭН:** **ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ:**

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГХБХБГ-ЫН ДАРГА .......................................................... /Э.ЧАГНААДОРЖ/

*(албан тушаал)* *(гарын үсэг) (тэмдэг)*

2022.06.15